

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2024 оны .. дугаар
сарын ...- ны ... өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээ, гэрчилгээний
загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3, 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар, тодорхойлолт”- ыг 2 дугаар хавсралтаар, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл олгогч эрх бүхий байгууллага, зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд хооронд байгуулах гэрээний загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийг бүртгэх, хянах ажлыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн зохион байгуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газар (Э.Батболд)-т даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбатад үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 245 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.ДАВААСҮРЭН

Барилга, хот байгуулалтын сайдын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх

Хот байгуулалтын баримт бичгийн ангилал	Байвал зохих инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/	Инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы ажлын туршлага, тавигдах шаардлага
ХБ-1.1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	<p>Хот төлөвлөлтийн архитектор-2</p> <p>Ландшафтын архитектор-1</p> <p>Хот төлөвлөлтийн эдийн засагч-1</p> <p>Экологич-1/гэрээт/</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын инженер-1</p> <p>Цахилгааны инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын инженер-1</p> <p>Дулааны инженер-1</p> <p>Усны барилга байгууламжийн инженер-1/гэрээт/</p>	<p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй архитектор-1</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Цахилгааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Дулааны мэргэшсэн зэрэгтэй инженер-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн эдийн засагч-1 тус тус байна.</p> <p><i>Геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн төлөвлөлтийн хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i></p>

	Зам, гүүрийн инженер-1/гэрээт/ Тээврийн инженер-1/гэрээт/	
ХБ-1.2.Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл	Хот төлөвлөлтийн архитектор-2 Ландшафтын архитектор -1 Хот төлөвлөлтийн эдийн засагч-2 Бүс нутаг төлөвлөгч-1 Архитектор -1 Газар зохион байгуулагч-1 Газарзүйч-1 Экологич-1 /гэрээт/ Ус хангамж, ариутгах татуургын инженер-1 Цахилгааны инженер-1 Холбоо, дохиоллын инженер-1	Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-1 Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй архитектор-1 Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй эдийн засагч-1 Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч-1 Ус хангамж, ариутгах татуургын мэргэшсэн зэрэгтэй инженер -1 Цахилгааны мэргэшсэн зэрэгтэй инженер -1 Холбоо, дохиоллын мэргэшсэн зэрэгтэй инженер -1 Дулааны мэргэшсэн зэрэгтэй инженер -1 Усны барилга байгууламжийн мэргэшсэн зэрэгтэй инженер -1 Газар зохион байгуулагч мэргэшсэн зэрэгтэй инженер-1 Геодезийн мэргэшсэн зэрэгтэй инженер-1 <i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, байгаль орчны</i>

	<p>Дулааны инженер-1</p> <p>Усны барилга байгууламжийн инженер-1/гэрээт/</p> <p>Зам, гүүрийн инженер-1/гэрээт/</p> <p>Геодезийн инженер-1</p> <p>Тээврийн инженер-1/гэрээт/</p> <p>Логистикийн инженер -1/гэрээт/</p> <p>Зургийн техникч - 2</p>	<p><i>үнэлгээ, дэд бүтцийн төлөвлөлтийн хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i></p>
<p>ХБ-1.3.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл</p>	<p>Хот төлөвлөлтийн архитектор-8</p> <p>Хот төлөвлөлтийн эдийн засагч-2</p> <p>Эдийн засагч-2</p> <p>Бүс нутаг төлөвлөгч-1</p> <p>Архитектор-1</p> <p>Газар зохион байгуулагч-2</p>	<p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор-2</p> <p>Мэргэшсэн зэрэгтэй архитектор-4</p> <p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч-1</p> <p>Барилгын зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Ус хангамж, ариутгах татуургын зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Цахилгааны зөвлөх зэрэгтэй инженер-1</p> <p>Холбоо, дохиоллын зөвлөх зэрэгтэй инженер-1</p>

	Газарзүйч-1	Дулааны зөвлөх зэрэгтэй инженер-1 Усны барилга байгууламжийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Экологич-1	Геодезийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Барилгын инженер-1	Инженер геологийн зөвлөх зэрэгтэй инженер-1
	Ус хангамж, ариутгах татуургын инженер-2	Зам, гүүр, тээврийн хөдөлгөөний зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй инженер тус бүр 1
	Цахилгааны инженер-2	<i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээний хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i>
	Холбоо, дохиоллын инженер-2	
	Дулааны инженер-2	
	Усны барилга байгууламжийн инженер-1	
	Зам, гүүрийн инженер-1	
	Тээврийн инженер-1	
	Геодезийн инженер-1	
	Инженер- геологийн инженер-1	
	Мэдээллийн сангийн мэргэжилтэн-1	
	Хүн ам зүйч-1	

Тайлбар:

1.Тусгай зөвшөөрлийн хүсэлтээ барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим систем "license.mcis.gov.mn"-ээр дамжуулан гаргана.

2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан болон инженер, техникийн ажилтнууд /мэргэжилтэн/-ын дээрх хүснэгтэд заасан ажлын туршлага, тавигдах шаардлагын дагуу "ДАН" танилт нэвтрэлтийн систем болон "ХУР" системээр дамжуулан дараах мэдээллийг баталгаажуулна. Үүнд:

-аж ахуйн нэгж, байгууллагын /улсын/ бүртгэлийн мэдээлэл;

-иргэний үнэмлэхний мэдээлэл;

-нийгмийн даатгалын мэдээлэл;

-дээд боловсролын мэдээлэл.

3.Аж ахуйн нэгж, байгууллага шинээр эрх авах хүсэлт гаргасан тохиолдолд инженер, техникийн ажилтны /мэргэжилтэн/ нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 1 сар, нэмэлт ажлын төрөл авах болон эрх сунгах, дахин олгуулах хүсэлт гаргасан тохиолдолд сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн байна.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ

1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд олгох зөвшөөрлийн гэрчилгээний /цаашид “гэрчилгээ” гэх/-ний загварыг тодорхойлов.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь 4 шатлал бүхий нууцлалтай, үнэт цаас байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

4. Гэрчилгээний өргөн нь 210 мм, урт нь 297 мм 5 мм байна.

5. Гэрчилгээний дэвсгэр С-51%, М-2%, Ү-7%, К-0% кодын цэнхэр өнгөтэй байх ба 11 мм-ийн өргөнтэй С-100%, М-52%, Ү-20%, К-31% кодын цайвар цэнхэр өнгийн сүлжмэл хээн хүрээтэй байна.

6. Гэрчилгээний дээд хэсэгт 22.5 x 45 мм хэмжээтэй соёмбыг байрлуулна. Соёмбо нь MNS6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна.

7. Соёмбын хажуу талд тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар байна.

8. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарыг 7-н оронтой (00-000/00) тоогоор тэмдэглэж, ангилал, кодыг оруулах ба 00- аймаг, дүүргийн код (MNS 5641-2:2006 стандартад заасан), 000-тухайн жилд олгогдож буй тусгай зөвшөөрлийн дугаар, 00-тусгай зөвшөөрөл олгогдсон оны сүүлийн хоёр оронг илэрхийлнэ.

9. Соёмбын доод талд тусгай зөвшөөрөл олгосон хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг С-100%, М-52%, Ү-20%, К-31% кодын хөх өнгөөр, том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 24) бичсэн байна.

10. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд, С-51%, М-2%, Ү-7%, К-0% кодын хөх өнгөөр том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 96) “ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” гэсэн гарчиг байх ба түүний доод талд тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарыг бичнэ.

11. Гэрчилгээ нь “Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.8-д заасныг тус тус үндэслэн.....аймаг /нийслэл/-ийнсум /дүүрэг/-ийн-д хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийгоныдугаар сарын-ны өдрөөсжилийн хугацаатай олгов. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байх бөгөөд гэрчилгээний загварыг тодорхойлолтод хавсаргав.

12.Гэрчилгээний доод талд гэрчилгээ олгосон Барилга, хот байгуулалтын сайдын нэр, олгосон огноо, олгосон газрыг бичсэн байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ АР ТАЛ, АГУУЛГА

13.Гэрчилгээний ар талын дээд хэсэгт “Сунгалтын тэмдэглэл:” гэснийг жижиг үсгээр, доод хэсэгт “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийгоныдугаар сарын-ны өдрөөс жилийн хугацаатай сунгав.” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байх ба түүний доод талд Барилга, хот байгуулалтын сайдын нэр, огноо байна.

14.Гэрчилгээний ар талын доод хэсэгт “Хуулийн этгээдийн захирал /дарга/:
..... Хаяг:..... Утас:.....
Факс:..... E-mail:.....” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

15.Гэрчилгээ нь хавсралттай байх бөгөөд хавсралт нь гэрчилгээний салшгүй хэсэг байна.

16.Хавсралтын баруун дээд талд “Гэрчилгээний хамт хүчинтэй” гэсэн бичиглэл, түүний доод талд “ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ” гэсэн гарчиг, түүний доод талд “Нэмэлтээр эрхлэх үйл ажиллагаа” гэсэн бичвэр бичигдэнэ.

17.Хавсралтын доод талд баталгаажуулсан Барилга, хот байгуулалтын сайдын нэр, нэмэлт өөрчлөлтийг оруулсан огноог оруулна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН АР ТАЛ, АГУУЛГА

18.Хавсралтын дээд талд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэр, түүний доод талд зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг жил бүр дүгнэсэн тухай тэмдэглэл, гэрээ дүгнэсэн албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тэмдгийг дарах зориулалттай хүснэгт байх ба гэрээ дүгнэсэн огноо, тэмдэглэгээ хийсэн албан тушаалтны нэр, баталгаажуулсан “тэмдэг”-ийг дарсан байна.

СОЁМБО

Серийн дугаар

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Бүртгэлийн дугаар

Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, , Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.8-д заасныг тус тус үндэслэн.....аймаг/нийслэл/-ийн.....сум /дүүрэг/-ийн

.....-д

/улсын бүртгэлийн дугаар/

/регистрийн дугаар/

..... хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг оны дугаар сарын-ны өдрөөсжилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ

БАЙГУУЛАЛТЫН САЙД _____ /гарын үсгийн тайлал/

Улаанбаатар хот

огноо

АР ТАЛ

Сунгалтын тэмдэглэл:

Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг оныдугаар сарын -ны өдрөөс жилийн хугацаатай сунгав.

БАРИЛГА, ХОТ

БАЙГУУЛАЛТЫН САЙД _____ /гарын үсгийн тайлал/

ОГНОО

Хуулийн этгээдийн захирал /дарга/:...../гарын үсгийн тайлал/

Хаяг:.....

Утас:..... Факс:..... E-mail:.....

НҮҮР ТАЛ

..... дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралт

Гэрчилгээний хамт хүчинтэй.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАВСРАЛТ

Нэмэлтээр эрхлэх үйл ажиллагаа:

.....

.....

.....

.....

.....

.....

БАРИЛГА, ХОТ

БАЙГУУЛАЛТЫН САЙД _____ /гарын үсгийн тайлал/

ОГНОО

Барилга, хот байгуулалтын сайдын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын 3 дугаар хавсралт

БАТЛАВ.

“ ”
Тусгай зөвшөөрөл олгогч эрх бүхий байгууллагыг
төлөөлж

БАТЛАВ.

“ ”
Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг
төлөөлж

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОГЧ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД
ХООРОНД БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

... оны ... дугаар сарын
... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд /цаашид "зөвшөөрөл эзэмшигч" гэх/ бүр **Барилга, хот байгуулалтын яам** /цаашид "эрх бүхий байгууллага" гэх/ -тай энэхүү гэрээг байгуулж ажиллана.

1.2.Эрх бүхий байгууллага, зөвшөөрөл эзэмшигч хоёр тал хууль эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа хамтран хэрэгжүүлэхэд гэрээний зорилго оршино.

1.3.Талууд нь Зөвшөөрлийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журмын хүрээнд энэхүү гэрээг байгуулж, хууль тогтоомжид заагдсан эрх, үүргийг хүлээнэ.

1.4.Нэг талаас эрх бүхий байгууллагыг төлөөлж **Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын дарга****овогтой**, нөгөө талаас зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж "....." **ХХК-ийн** **овогтой** нар нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Эрх бүхий байгууллагын эрх, үүрэг

2.1. Эрх бүхий байгууллага нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээдийн бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн акт, норм норматив, техникийн баримт бичгүүдийн талаарх мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллана;

2.1.2. зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд нь авч, мэдээллийн санд нэгтгэх, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, тэдний ажил, үйлчилгээний талаар тодорхойлолтыг гаргаж өгөх, салбарын бодлого, чиглэлийг боловсруулахад ашиглана;

2.1.3. мэргэжил дээшлүүлэх, гадаад, дотоодын ижил төстэй ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын туршлагыг судлах, дадлага хийх, үзэсгэлэн, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулах, үйл ажиллагаагаа өргөтгөхөд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлнэ;

2.1.4. зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн тайлан болон холбогдох бичиг баримтыг үндэслэн инженер, техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулна;

2.1.5. зөвшөөрөл эзэмшигч байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдамж, чиглэлийг өгөх, мэдээ тайланг хугацаанд нь авч байна.

Гурав. Зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Зөвшөөрөл эзэмшигч нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийн ажлын төрөл, суурь болон тусгай нөхцөл, шаардлагыг хангаж, олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил үйлчилгээ эрхэлнэ.

3.2. Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 206, А/184 дугаартай тушаалын хавсралт маягтын дагуу мэдээ, тайланг жилд 2 удаа буюу хагас жилийн байдлаар тухайн оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор "www.mcis.gov.mn" цахим системээр ирүүлнэ. (үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны тайланг "Х" –ээр ирүүлнэ).

3.3. Зөвлөх болон мэргэшсэн, бусад инженер, техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийн тэмдэглэл /суурин утас, факс, E-майл хаяг, шуудангийн хаяг/-ийг эрх бүхий байгууллагад мэдэгдэж, тэмдэглэлийг хийлгэнэ.

3.4. Мэдээллийн санд бүртгэлтэй инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/ нь цахим системд бүртгэгдсэнээс хойш 90 хоногийн дотор шилжилт, хөдөлгөөн хийхгүй бөгөөд шилжилт, хөдөлгөөн хийсэн тохиолдолд зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж,

байгууллага нь нөхцөл, шаардлагад заасан инженер техникийн ажилтан /мэргэжилтэн/-ыг 30 хоногийн дотор нөхөн бүртгүүлнэ.

3.5.Зөвшөөрөл эзэмшигч нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага дахь мэргэшлийн зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн /хот төлөвлөлтийн архитектор болон эдийн засагч/ нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхтэй 3 хүртэлх аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллаж болно. Энэ тохиолдолд гэрээг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

3.6.Зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийг авснаас хойш ажлын 7 хоногийн дотор харьяалагдах татварын албанд эрхлэх үйл ажиллагааны чиглэлээ бүртгүүлсэн байна.

3.7.Тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, журам, заавар, альбом, каталог зэрэг техникийн баримт бичгүүдийн фондыг тогтмол баяжуулна.

3.8.Инженер, техникийн ажилтан /мэргэжилтэн/-ы мэргэшлийг дээшлүүлэх, мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулна.

3.9.Эрх бүхий байгууллагын зүгээс зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, сургалт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд инженер, техникийн ажилтан /мэргэжилтэн/-аа бүрэн хамруулах, удирдамж чиглэл авна.

3.10."Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ийн 3.2.3-т заасны дагуу Норм, нормативын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тоот дансанд төлнө.

3.11.Зөвшөөрөл эзэмшигч нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28.1.9, 42.6-д тус тус заасан хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зөвшөөрөл олгох шийдвэр гарсныг эрх бүхий байгууллагаас мэдэгдсэнээс хойш ажлын гурван өдөрт багтаан 900,000.0 (есөн зуун мянган) төгрөгийг <https://itax.mta.mn/home> сайт руу хандан орж төлбөрийн даалгавар үүсгэн төлнө.

Дөрөв.Гэрээг цуцлах хугацаа, үндэслэл

4.1.Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.2.Зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй болон Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1-т заасан тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдол гэрээг цуцалсанд тооцно.

4.3.Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд тусгай зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан өдрөөс тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, хүчингүй болох хүртэл хугацаанд хүчинтэй байна.

Тав. Гэрээний тусгай тэмдэглэл

5.1.Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа:

.....
"Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах (ХБ-1.1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)";

"Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах (ХБ-1.2.Бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл)";

"Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах (ХБ-1.1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)";

5.2.Зөвшөөрөл эзэмшигчийн байршил, хаяг:

Хаяг:.....

Утас:..... Факс:..... Цахим хаяг:.....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эрх бүхий байгууллагаийг төлөөлж:

Зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

Барилга, хот байгуулалтын яамны
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот
байгуулалтын газрын дарга

"....." ХХК-ийн

.....

.....

Утас:

Утас:

Барилга, хот байгуулалтын яамны
Хуулийн хэлтсийн дарга

.....

Утас:

---oOo---